



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/014/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>НТАГ-ын Дэд дарга Ч.Болд</p> <p>Утас: Цахим хаяг: boldch@audit.gov.mn</p> <p>Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга</p> <p style="text-align: right;">Х.Түвшинбаяр</p> <p>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс</p> <p>Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Одончимэг</p> <p>Утас: 325093 Цахим хаяг: odonchimegb@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.24 № 01/83
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ
ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА
Б.ЭНХТӨГС ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Налайх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөг эс тооцвол Нийслэлийн Налайх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 123,108.1 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 1,260,733.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, үүний 5.7 хувь буюу 71,398.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байгаагийн 50.6 хувь нь шүүх ажиллагаанд, 37.1 хувь нь эвлэрлийн хугацаанд, 12.3 хувь нь нас барсан иргэдийн авлага эзэлж, авлага барагдуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2024 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулан нийт 760,100.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн гэрээг 112 иргэнтэй, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд нийт 114,430.1 мянган төгрөгийн гэрээг 13 аж ахуй нэгжтэй байгуулан ажилласан байна.

02073412

Бусад асуудлын хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрт тусгасан болон тус сангаар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэл, зарцуулалт, хүрсэн үр дүн зэрэг асуудлуудыг аудитын цаг хугацаа, хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитад бүрэн хамруулаагүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,529,608,281.67</u>	<u>1,260,733,375.53</u>
33	АВЛАГА	1,529,608,281.67	1,260,733,375.53
33300	Татаас, санхүүжилтийн авлага	284,551,800.00	-
335	Бусад авлага	1,245,056,481.67	1,260,733,375.53
3351	Байгууллагаа авах авлага	0.00	29,700,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,245,056,481.67	1,231,033,375.53
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,529,608,281.67</u>	<u>1,260,733,375.53</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,060,000.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,060,000.00	-
413	Өглөг	3,060,000.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	60,000.00	-
4136	Бусад өглөг	3,000,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	3,000,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,526,548,281.67</u>	<u>1,260,733,375.53</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,526,548,281.67	1,260,733,375.53
512	Хуримтлагдсан үр дүн	1,526,548,281.67	1,260,733,375.53
51210	Өмнөх үеийн үр дүн	1,053,198,027.00	1,425,608,281.67
51220	Тайлант үеийн үр дүн	473,350,254.67	(164,874,906.14)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,529,608,281.67</u>	<u>1,260,733,375.53</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,171,145,000.00	1,297,484,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,243,000.00	285,964,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,243,000.00	285,964,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,243,000.00	6,280,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,243,000.00	6,280,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,169,902,000.00	1,291,204,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,169,902,000.00	1,291,204,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,169,902,000.00	1,291,204,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	697,794,745.33	1,462,358,906.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	697,794,745.33	1,492,058,906.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,626,700.00	52,729,830.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,626,700.00	52,729,830.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,626,700.00	52,729,830.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	642,168,045.33	1,439,329,076.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	201,339,000.00	264,738,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	201,339,000.00	235,038,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	296,336,170.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	296,336,170.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	440,829,045.33	878,254,906.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	440,829,045.33	878,254,906.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>473,350,254.67</u>	<u>(164,874,906.86)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>473,350,254.67</u>	<u>(164,874,906.86)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,171,145,000.00</u>	<u>1,582,035,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,243,000.00	290,831,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,243,000.00	290,831,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,243,000.00	290,831,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,243,000.00	6,280,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		284,551,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,169,902,000.00	1,291,204,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,169,902,000.00	1,291,204,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,169,902,000.00	1,291,204,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,618,786,545.33</u>	<u>2,169,458,906.14</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,618,786,545.33	2,169,458,906.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,466,700.00	44,914,830.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,466,700.00	44,914,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,466,700.00	44,914,830.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,564,319,845.33	2,124,544,076.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	838,939,000.00	949,953,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	838,939,000.00	949,953,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	284,551,800.00	296,336,170.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,551,800.00	296,336,170.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	440,829,045.33	878,254,906.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	440,829,045.33	878,254,906.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(447,641,545.33)</u>	<u>(587,423,106.14)</u>
14	Бусад эх үүсвэр	447,641,545.33	587,423,106.14

145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	447,641,545.33	587,423,106.14
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>447,641,545.33</u>	<u>587,423,106.14</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,053,198,027.00	1,053,198,027.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,053,198,027.00	1,053,198,027.00
C07	Тайлант үеийн үр дүн	473,350,254.67	473,350,254.67
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,526,548,281.67	1,526,548,281.67
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,526,548,281.67	1,526,548,281.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-100,940,000.00	-100,940,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,425,608,281.67	1,425,608,281.67
D08	Тайлант үеийн үр дүн	-164,874,906.14	-164,874,906.14
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,260,733,375.53	1,260,733,375.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,291,204,000.0	994,867,830.0	296,336,170.00	77.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,291,204,000.0	994,867,830.0	296,336,170.00	77.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,750,000.0	44,914,830.0	10,835,170.00	80.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,750,000.0	44,914,830.0	10,835,170.00	80.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,750,000.0	44,914,830.0	10,835,170.00	80.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,235,454,000.0	949,953,000.0	285,501,000.00	76.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,235,454,000.0	949,953,000.0	285,501,000.00	76.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,235,454,000.0	949,953,000.0	285,501,000.0	76.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,291,204,000.0	994,767,830.0	296,436.170.00	77.0
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,291,204,000.0	994,767,830.00	296,436,170.00	77.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 343,536.2 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 123,108.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 29,700.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 93,408.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс						Зөвлөмж
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Налайх дүүргийн ХЭДСан	4	343,536.2	2	44,700.0	2	298,836.2	4	343,536.2					
Дүн	4	343,536.2	2	44,700.0	2	298,836.2	4	343,536.2					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Налайх дүүргийн ХЭДСан	4	123,108.0			1	29,700.0	3	93,408.0				
Дүн	4	275,103.9			1	29,700.0	3	93,408.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Налайх дүүргийн ХЭДС	1	83,130.1						1	83,130.1
Дүн	1	83,130.1	0	0				1	83,130.1

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		